

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.03.24**




## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- АНУ-ын ХНС бодлогын хүүгээ хэвээр нь хадгаллаа. Харин 6-р сараас эхлэн хүүг бууруулж эхэлнэ.
- Трамп хүүгээ бууруул гэж шаардаж эхлэв.
- АНУ-ын зах зээл ёроолдоо хүрсэн үү?
- Брокерын компаниуд Хятадын ДНБ-ий өсөлтийн таамгаа өсгөсөн
- Эдийн засгийн өсөлтийн зорилтоо гурав дахь жилдээ дараалан 5 орчим хувь гэж тогтоосон юм.
- Ant Group хиймэл оюун ухааны загваруудыг сургах зардлыг бууруулах хямд өртөгтэй аргуудыг Хятадад үйлдвэрлэсэн хагас дамжуулагч ашиглан боловсруулжээ.

S&P 500 индексийн  
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.03.17--03.23

## ХНС ХҮҮГЭЭ ХЭВЭЭР НЬ ХАДГАЛАВ

АНУ-ын эдийн засагт гаалийн тарифын өсөлт, эдийн засгийн саармагжилт зэрэг эрсдэл тулгарч байгаа тул Холбооны Нөөцийн Сангаас бодлогын хүүг хэвээр хадгаллаа.

Гэхдээ энэ онд хүүг бууруулах төлөвтэй байна. Тодруулбал, 2025 онд 0.5 хувиар хүүг бууруулах боломжтой гэж үзэж байгаа тул 2 удаагийн шийдвэрээр нийт 0.25 хувиар буурах төлөвтэй байна.


ХНС-ийн дарга Жером Пауэлл тарифын нөлөөг тодорхойгүй гэж үзэж байгаа бөгөөд “түр хугацаанд инфляц өсөх ч дараа нь намдах магадлалтай” хэмээн мэдэгджээ.

✂ Эрсдэл ба хүлээлт:

- Хүүг бууруулах нь тарифтай хослоод инфляцыг улам нэмэгдүүлж болзошгүй.
- Зах зээл 6-р сар хүртэл ХНС хүү бууруулахгүй гэж таамаглаж байна.

ХНС-ийн шинэ таамаглалд дурдсанаар, дараагийн гурван жилд 1% орчим бууралтын зай байна гэж үзжээ.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРЫН АЙДСЫН ТҮВШИН



Нийт хүмүүсийн 57%-иас дээш нь "зах зээл унах нь" гэж айж эхэлсэн үеийг харуулж байгаа. Түүхэнд ийм үе 3 удаа тохиолдсон – 1990, 2009, 2022 онд – бүгд дараа нь S&P 500 индекс хүчтэй өссөн (+36.21% дундаж өсөлттэй). Хамгийн гол нь: яг одоо 2025 оны 3-р сард мөн ийм айдас дээд цэгтээ хүрч, өмнөх ёроолуудын үеийнхтэй адил статистик харагдаж байна. Энэ нь зах зээл одоо ёроолд хүрсэн байж МАГАДГҮЙ, удахгүй өсөлт эхлэх дохио гэж ойлгож болно.





## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.03.17-03.23

### ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАСВАРЫН ХӨДӨЛГӨӨН ЭХЭЛЛЭЭ

Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл сүүлийн хоёр долоо хоногийн өсөлтийн дараа хөрөнгө оруулагчид болгоомжтой хандаж эхэлснээр засварын хөдөлгөөн орж эхэллээ. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын голлох CSI 300 индекс 2.29%-иар, Шанхайн нэгдсэн индекс 1.60%-иар буурчээ. Харин Хонконгийн Хан Сенг индекс 1.13%-иар унасан байна.

Хятад улс оны эхэнд эдийн засаг тогтвортой өсөлттэй гарсныг харуулсан хэд хэдэн таамгаас давсан үзүүлэлтүүдийг нийтэлжээ. Жилийн өмнөх үетэй харьцуулахад 1-р, 2-р сарын нийлсэн байдлаар жижиглэн худалдаа 4.0%-иар өссөн нь 11-р сараас хойших хамгийн хурдан өсөлт байлаа. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл мөн хугацаанд 5.9%-иар өссөн нь 12-р сарын 6.2%-аас удааширсан ч хүлээлтээс давсан үзүүлэлт болсон. Үл хөдлөх хөрөнгө болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг багтаасан хөрөнгө оруулалт 1-2-р сард жилийн өмнөхтэй харьцуулахад 4.1%-иар өссөн нь мөн л таамгаас давж, 12-р сарын 3.2%-иас өссөн дүн байв. Хятадын статистикийн газар нь Сар шинийн баярын огноо жил бүр өөрчлөгддөгтэй холбоотойгоор 1, 2-р сарын үзүүлэлтүүдийг хамтад нь нэгтгэж мэдээлдэг.


Гэсэн ч эдийн засгийн зарим салбарууд сул хэвээр байгааг харуулсан тоон мэдээлэл гарсан байна. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт 2025 оны эхний хоёр сард жилийн өмнөхөөс 9.8%-иар буурсан нь 12-р сард бүртгэгдсэн 10.6%-ийн уналтаас бага зэрэг дээрдсэн ч энэ салбарын олон жил үргэлжилсэн уналт хараахан дуусаагүйг илтгэж байна. Мөн хотын ажилгүйдлийн түвшин 5.4%-д хүрч, сүүлийн хоёр жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн гэж Ройтерс мэдээлжээ.

Эдгээр үзүүлэлтүүдийн дараа хэд хэдэн брокерын компаниуд Хятадын ДНБ-ий өсөлтийн таамгаа өсгөсөн бөгөөд энэ нь Вашингтонтой үүсч болзошгүй худалдааны зөрчлийн эрсдэлийг үл харгалзан Бээжин жил бүрийн өсөлтийн зорилтоо биелүүлж чадна гэсэн итгэлийг илтгэж байна. 3-р сарын эхээр болсон Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын үеэр Хятад улс эдийн засгаа дэмжих хүчтэй төсөв, мөнгөний бодлого баримтлахаа амлаж, 2025 онд хэрэглээг нэмэгдүүлэхийг засгийн газрын тэргүүлэх зорилт болгосноо мэдэгдсэн. Мөн эдийн засгийн өсөлтийн зорилтоо гурав дахь жилдээ дараалан 5 орчим хувь гэж тогтоосон юм.

### ANT GROUP ЗАРДАЛ БУУРУУЛАХ ШИНЭ АРГА ГАРГАЛАА

Блүүмбергийн Даваа гарагт мэдээлснээр, Жэк Ма-гийн Ant Group хиймэл оюун ухааны загваруудыг сургах зардлыг бууруулах хямд өртөгтэй аргуудыг Хятадад үйлдвэрлэсэн хагас дамжуулагч ашиглан боловсруулжээ.

Мэдээлэлд ойр эх сурвалжийн хэлснээр, эдгээр аргууд нь хиймэл оюун ухаан сургах зардлыг 20% хүртэл бууруулах боломжтой бөгөөд Ant Group-ийн түнш Alibaba Group (NYSE:BABA) болон Хятадын технологийн томоохон компани Huawei Technologies-ийн үйлдвэрлэсэн дотоодын чипүүдийг ашиглан хөгжүүлсэн байна.



## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 17, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 360 Finance	 Hightide Fgen	 Sundial Fgen	 Stone	 Signet Jewellers	 Five Below	 Pinduoduo Inc.	 Micron	 NIO	
 Protalix Biotherapeutics	 FibroGen	 Xpeng	 Maravai LifeSciences	 Williams-Sonoma	 Frontview Asia Ltd.	 Academy Sports & Outdoors	 Nike	 Carnival Corporation & PLC	
 Townsquare Media	 OpenLending	 Bitcoin Depot	 HealthEquity	 Ollie's Good Stuff Chefs	 North American Construction	 Jabil	 FedEx	 Mini-SOC	
 SAIC	 Sangamo Therapeutics	 Huya	 Waldencast	 General Mills	 Worthington Steel	 Darden Restaurants	 Lennar	 Sow Good	
 Inspired by Dec	 Harrow Health Inc.	 Elbit Systems	 ZTO Express	 Kingsport Cloud	 Joyo	 Accenture	 Planet		
 Diversified Energy	 Mesa Energy Services Inc.	 Beke	 Surfair Mobility	 Sportradar	 MSC Income Fund	 Lands' End	 KinderCare Learning Companies		
 Sonida Senior Living QTRHF	 RF Industries	 eTon Pharmaceuticals	 Inovio	 Tencent	 GoldRoyalty	 Gambling.com	 Amprion		
 Quarterhill	 Lithium Argentina	 Tencent Music Entertainment CWCQ	 Absci	 Jill	 Aeva Capri	 Factset	 Vaxart		
	 Getty Images	 Consolidated Water	 OmniAb	 MediWound	 Capricor	 Shoe Carnival	 Scholastic		
	 HNRG	 IHS		 Neonode		 Adaptimmune	 Torrid		
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>						© 2025 Earnings Whispers			

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 24, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 Intuitive Machines	 Oklo	 Canadian Solar	 GameStop	 Dollar Tree	 MicroVision	 Bitfarms	 Lululemon	 Ipa	
 Lucid diagnostics	 Kb Home	 Atour Group	 SurgePays	 Chewy	 Concentrix	 Winnebago	 Kulr	 SBC	
 Dragonfly	 Enerpac Tool Group	 Rumble	 Worthington Industries	 Cintas	 3D Systems	 TD Synnex	 Braze	 Katapult	
	 Intelliclinics	 McCormick	 Beta Bionics	 Target Hospitality	 USIO	 Sachem	 Abacus Life	 Super Leaf	
	 ABVX	 CorMedix	 KOLIBRI	 JinKo Solar	 Verint	 Ten Ltd	 FitLife	 zSpace	
	 ABIVAX	 Smithfield	 Access Newswire	 Paychex	 Petco	 Innate Pharma	 AAR	 LIQTECH	
	 ONCOCYTE	 Core & Main	 GCT	 DQOO	 Durect	 PDS Biotechnology	 Oxford		
	 SKYX	 Haidilao	 NOAH	 REX American Resources Corporation	 Steelcase	 ADC Therapeutics	 HireQuest Inc.		
	 ASNS	 PAVmed	 Paysign	 CollPlant	 MillerKnoll	 Acumen	 VirTra		
	 Actelis	 Pony	 Corvus Pharmaceuticals	 Canaan	 H.B. Fuller	 IceCure	 Plus Therapeutics		
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>						© 2025 Earnings Whispers			